



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 18/01

Номгон

Г Аймгийн 2023 оны төсвийн үлдэгдлийг 2024 оны төсөвт батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.9, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолын 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн 2023 оны төсвийн үлдэгдэл 193,000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардалд баталсугай.

2. Төсвийн үлдэгдлийг зудын эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авахад зарцуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3. Сумууд 2023 оны төсвийн үлдэгдлийг дахин хуваарилж батлахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт, баталсан төсвийг зудын эсрэг хариу арга хэмжээ авахтай холбогдон гарч буй зардалд зарцуулах зорилгоор Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлж нэн шаардлагатай зардлыг санхүүжүүлэхийг сумдын Засаг дарга нарт чиглэл болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



0121396